

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1, Монгол Улсын Ерөнхий сайдын 2018 оны 198 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Монгол Улсын нийслэл Улаанбаатар хот болон “Датакарт концерциум”-ын хооронд 2014 оны 09 дүгээр сарын 18-ны өдөр байгуулсан “Улаанбаатар хотын нийтийн тээврийн үйлчилгээнд удирдлага, мэдээллийн болон цахим төлбөрийн систем нэвтрүүлэх төслийг хэрэгжүүлэх гэрээ”-ний биелэлтийг дүгнэж, санал дүгнэлт танилцуулах үүрэг бүхий Ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай:

- Ахлагч: -Улаанбаатар хотын ерөнхий менежер бөгөөд Захирагчийн ажлын албаны дарга Т.Гантөмөр
- Гишүүд:
- Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга А. Даваажаргал;
 - Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга Г.Өлзийбаяр;
 - Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга Э.Ганхүү;
 - Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсийн дарга Х.Гантулга;
 - Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Инженерийн байгууламжийн хэлтсийн дарга Т.Хэрлэн;
 - Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Аудит, дотоод хяналтын хэлтсийн дарга Ц.Рэгзэдмаа;
 - Нийслэлийн Тээврийн газрын дарга Д.Отгонбаатар;
 - Нийслэлийн Дотоод аудитын албаны дарга Б.Жавзан;
 - Нийслэлийн Мэдээллийн технологийн газрын дарга О.Чинзориг;

-Нийслэлийн Өмчийн харилцааны газрын дарга Ч.Однасан;

-Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн мэргэжилтэн С.Энхжаргал;

-Том оврын автобусаар үйлчилгээ эрхлэгчдийн холбооны Ерөнхий захирал Б.Алтанцэцэг;

Нарийн бичгийн
дарга

-Нийслэлийн Тээврийн газрын Захиргааны удирдлага,
санхүүгийн хэлтсийн дарга М.Мөнхбаяр.

2.Гэрээг дүгнэхтэй холбогдуулан удирдамж боловсруулан, захирамжийн 1 дүгээр зүйлд заасан чиглэлийн хүрээнд ажиллаж, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал, дүгнэлтийг 2019 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн дотор Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулахыг Ажлын хэсэг /Т.Гантөмөр/-т даалгасугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН НОГООН ХӨГЖИЛ,
АГААРЫН БОХИРДЛЫН АСУУДАЛ ХАРИУЦСАН
ОРЛОГЧ Ж.БАТБАЯСГАЛАН